



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА ХОВД АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

*Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн зарцуулалтанд
хийсэн нийцлийн аудитын тайлан*



**САНГИЙН ХӨРӨНГИЙГ ЖУРАМД ЗААСАН
ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛЖЭЭ.**

Ховд хот

2016 он

Агуулга

Аудитыг гүйцэтгэж тайланг бэлтгэсэн:	Товчилсон үгийн жагсаалт	1
ҮАГ-ын харьяа Ховд аймгийн аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй стандартын талаарх мэдэгдэл	2
Тэргүүлэх аудитор Л.Галбадрах	Оршил	3
Аудитын менежер А.Цэцэгсүрэн		4
Аудитор Д.Балжинням	Бүлэг 1. Сангийн хөрөнгийн хууль, эрх зүйн зохицуулалт оновчтой байна.	4
	- МБСДСангийн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчин бүрджээ. - Сангийн үйл ажиллагааг зохицуулж буй хууль, дүрэм, журмууд нь бусад хууль тогтоомжтой нийцэж байна.	
2016 оны 10 дугаар сар	Бүлэг 2. Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийн хуульд заасны дагуу төлөвлөж бүрэн бүрдүүлж ажилласан байна.	5
Уг тайланг ҮАГ-ын Веб сайтаас үзнэ ҮҮ. www.audit.gov.mn	МБСДС хөрөнгийг хуульд заасны дагуу үндэслэлтэй төлөвлөсөн байна..	6
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70432545 дугаарын утас, 70433061 дугаарын факсаар харилцана уу.	БҮЛЭГ 3: Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг хууль, тогтоомжинд заасан зориулалтын дагуу зарцуулж үр дүн гарсан байна.	7
	- Сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл хөтөлбөр нь9 хуулиар тодорхойлогдсон зорилго, зорилттой нийцэж байна. - Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг бүрэн9 байршуулаагүй байна	9
	Аудитын дүгнэлт	10
	Аудитын зөвлөмж	
	Тэргүүлэх Аудиторын тушаал	11
	Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал:	12
	Хавсралт судалгаанууд.....	
ХАЯГ: Ховд аймаг Засаг даргын Тамгын газар Ховд аймаг Аудитын газар 3 давхар		

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

МБСДС	Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан
ҮАГ	Үндэсний Аудитын Газар
НА	Нийцлийн аудит
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ЗГТС	Засгийн газрын тусгай сан
ДЗОУБ	Дэлхийн зөн олон улсын байгууллага
ХАА	Хөдөө аж ахуйн

ОРШИЛ

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 21-26 дугаар зүйлийг үндэслэн 2010 онд Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан байгуулагдаж Засгийн газрын 2011 оны 117 тоот тогтоолоор Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журмыг баталсан байна

Мэргэжлийн боловсрол, сургалтад зарцуулах хөрөнгийг Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангаас санхүүжүүлэх бөгөөд Хөгжил Политехник коллежийн удирдлага ил тод хариуцлагатай захиран зарцуулах, хяналт тавих, тайлагнах үйл ажиллагааг энэ хуулийн 6.1-д заасан Зөвлөл болон хөдөлмөр, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тус тус ирүүлнэ гэснийг баримтлан хэрэгжүүлж байна.

Ховд аймгийг 2015 - 2025 онд хөгжүүлэх хөгжлийн хөтөлбөртэй уяалдуулан сургуулийн хөгжлийн чиг хандлагыг ХАА-н салбараар онцгойлон хөгжих эрэлт хэрэгцээ гарч байна гэж тодорхойлон сургуулиа хөгжүүлэх хөтөлбөр боловсруулан Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралд хэлэлцүүлэх шатандаа явагдаж байна.

Политехник коллеж нь 775 хүүхдийн суудал бүхий хичээлийн 2 байр, 350 хүүхдийн хүчин чадал бүхий 2 дотуур байр, дадлагын сургалтын 22 танхим, биеийн тамирын 2 заал, компьютерийн 3 лаборатори, 23000 ном бүхий номын фонд, уншлагын 3 танхим, 207 га хашиж хамгаалсан сургалт судалгаа хийх тариалангийн талбай, 8 айлын орон сууц, 130 тн багтаамжтай зоорь, ХАА-н машин механизмын авто парк зэрэг материаллаг байзтайгаар орон нутгийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан 1153 суралцагчдад 24 мэргэжлээр мэргэжлийн болон техникийн боловсролыг эзэмшүүлэхээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Сургуулийн материаллаг бааз, хүний нөөцөд түшиглэн алаг салат, огурцы, талх, алаш чулуун шал, ялуу гэх мэт бүс орон нутагтаа хүлээн зөвшөөрөгдсөн брэнд бүтээгдхүүнтэй болох зорилт тавин ажиллаж бэлэг дурсгалын морин хуур, алаг чулуун шал, эко тор, луувантай нарийн боов, төрөл бүрийн салат, чацарганы шүүс зэрэг бүтээгдэхүүн үйлдвэрлэн зах зээлд гаргах боломжтой болсон байна.

2015-2016 оны хичээлийн жилд шинэ мэргэжлээр ямар нэгэн сургалт эхлээгүй, баталгаажсан тусгай зөвшөөрлийн дагуу сургалтаа явуулж байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангаас суралцагчдад олгох - тэтгэлгийг 2015 онд 255,3 сая төгрөгөөр баталж 255,3 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

БҮЛЭГ 1: МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫГ ДЭМЖИХ


САНГИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТ, БҮРДҮҮЛЭЛТ:

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих санд орон нутгийн төсвөөс хөрөнгө хувиарлуулах шаардлагатай байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн жилийн орлого, зарлагын төсвийг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн баталж Хөдөлмөрийн яамны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгож байна.

Хөгжил Политехник коллежид мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын мэргэжлийн болон техникийн боловсролын түвшинд 2015-2016 оны хичээлийн жилд орон нутгийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан элсэлтийн тоог мэргэжлийн сургалтанд 17 мэргэжлээр 295 суралцагч, мэргэжлийн боловсролын сургалтанд 13 мэргэжлээр 175 суралцагч, техник боловсролын сургалтанд 3 мэргэжлээр 60 суралцагч нийт 575 суралцагч элсүүлэхээр элсэлтийн хяналтын тоог баталжээ. 2015-2016 оны хичээлийн жилд 550 суралцагч элсүүлж элсэлт 95,6%, 2016-2017 оны хичээлийн жилд нийт 570 суралцагч элсүүлэхээр элсэлтийн хяналтын тоог батлуулан тухайн хичээлийн жилд 524 суралцагч элсүүлж элсэлт 91% байна.

2013-2016 оны нийт элсэлтийн хяналтын тоо, үе



Элсэлтийн хяналтын тооноос үзэхэд 2014- 2015 оны хичээлийн жилд 34 хүүхдээр, 2015-2016 оны хичээлийн жилд 25 хүүхдээр, 2016-2017 оны хичээлийн жилд 36 хүүхдээр дутуу бүрдэж жил ирэх тусам элсэгчдийн тоо буурч байгаа нь суурь боловсрол эзэмшиж байгаа хүүхдийн тоо буурсантай холбоотой байна.

Мэргэжлийн боловсролын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2-д “Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих санд орон нутгийн төсвөөс олгох хөрөнгийн хэмжээг аймаг, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн жилийн орон нутгийн төсөвт тусгаж батална” гэсэн заалт хэрэгжихгүй байна.

Орон нутгийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан мэргэжилтэй ажилтан бэлтгэх, Ховд аймгийг 2015-2025 онд хөгжүүлэх хөгжлийн хөтөлбөртэй уяалдуулах хэрэгцээн дээр үндэслэн орон нутгаас тодорхой хэмжээний төсөв хувиарлуулан авч үйл ажиллагаагаа өргөжүүлэн материаллаг бааз, хүн хүчний нөөц бололцоогоо ашиглан туслах аж ахуйн орлогыг нэмэгдүүлэн ажиллах боломжыг ашиглах шаардлага гарч байна.

Тайлант онд Хөгжил Политехник коллежийн үйл ажиллагаанд улсын төсвөөс 1797,4 сая, үйл ажиллагааны орлогоос 16,0 сая төгрөг, МБСДсангаас 255,3 сая, нийт 2067,7 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон байна .

БҮЛЭГ 2: МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫГ ДЭМЖИХ САНГИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮН

Сангийн хөрөнгийг журамд заасны дагуу зарцуулсан байна.

2.1 2015 онд мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангаас суралцагчдийн тэтгэлэгт 255,3 сая төгрөгийн санхүүжилт олгож 251.1 сая төгрөгийн тэтгэлгийн зардал гаргаж 117,0 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Нийт сурагчдийн тоо				Нийт	Тэтгэлэг авсан	Олгосон тэтгэлэгийн дүн /мян.төг/	Зөрүү /мян.төг/
1-р анги	2-р анги	3-р анги	4-р анги		Олговол зохих тэтгэлэгийн дүн /мян.төг/		
4255	2443	1199		7897	439111.704	255258.183	183854

Тайлант онд давхардсан тоогоор 7897 суралцагчдад тэтгэлэг олгосон бөгөөд зөрүү 183,8 сая төгрөг 2015 оны 10 сараас эхлэн сургалтын байгууллага нь суралцагчийн тухайн сарын ирцийн мэдээллийг энэхүү журмын хавсралтанд заасан маягтын дагуу тооцон нэгтгэж дараа сарын 5 дотор мэргэжлийн боловсрол, Хөдөлмөр, нийгэм хамгаалалын яамны тэтгэмж хариуцсан мэргэжилтэнд хүргүүлж тухайн суралцагчийн харилцах дансанд шилжүүлдэг байна.

2.2 Сургалтын байгууллага мэргэжлийн боловсролын 1 болон 2,5 жил, техникийн боловсролын 1,5 болон 3 жилийн сургалтад хамрагдаж байгаа 24 хүртэлх насны онолын болон дадлагын сургалтад 75 хувиас доошгүй ирцтэй суралцагчдад тэтгэлэг олгож байна. Суралцагчдыг шинээр элсүүлсэн, төгсгөсөн болон анги дэвшүүлсэн, суралцагчдын шилжилт хөдөлгөөний тухай захиралын тушаалын хуулбарыг тухай бүр нь гаргаж байна.

2.3 Суралцагчдад олгосон тэтгэмжийн зардлыг тодруулбал 2015 оны 1-9 сарын тэтгэлэгт 246,2 сая төгрөгийг суралцагчдийн харилцах дансанд, суралцагчдийн зөвшөөрлөөр гэнэтийн ослын даатгалын хураамжыг тэтгэлгээс суутган Монгол даатгал ХХК-ны дансанд 8,9 сая төгрөгийг шилжүүлж байгаа нь МБСДС хөрөнгийг зарцуулах түүнд хяналт тавих журамд нийцэхгүй байгаа тул зөвлөмж өглөө.

2.4 Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ журмын 3,2-т заасан мэдээллийг хянан магадласны үндсэн дээр тэтгэлгийг суралцагчдийн дансанд сар бүр шилжүүлнэ гэсэн боловч суралцагчид 2016 оны 09 сарын 15 ны байдлаар 1,2 сарын тэтгэлгээ авсан 3,4,5,6 саруудын тэтгэлэг болох 149,8 сая төгрөгийг авч чадаагүй байна.


Тус хөтөлбөр хэрэгжсэнээр 2015 онд давхардсан тоогоор 489 хамрагдаж ерөнхий боловсролын бүрэн дунд боловсролын гэрчилгээ болон мэргэжлийн, техникийн боловсрол эзэмшиж нийт төгсөгчдийн 70,5% ажлын байраар бүрэн хангагдсан байна.

2.5 Мэргэжлийн боловсрол 489 суралцагч эзэмшнээс, дараагийн шатны техникийн болон их дээд сургуульд 24 хүүхэд дэвшин суралцсан байна.

2.6 Ажлын байрны захиалга нийлүүлэлт : 2015 оны төгсөгчдөөс Монос ХХК, Бөөргийн шугуй ХХК, Жуудайн ван ХХК, Хөсөгтөн транс ХХК, Гүн дэлгэр ХХК, Алтайн буйлааст ХХК, Өргөө ХХК зэрэг компианы захиалгаар 36 суралцагч ажлын байраар хангагдсан байна.

2.7 2015 оны жилийн эцэст Төсвийн ерөнхийлөн захирагчтай хийсэн бүтээгдхүүн нийлүүлэлтийн гэрээгээ дүгнүүлж 93% үнэлэгдэн салбартай тэргүүлэн ажилласан байна.

2.8 Хөгжил Политехник коллежийн сургалтын албанаас нийт төгсөгчдийн ажлын байр эрхлэлтэнд хийсэн судалгаанаас үзэхэд 70,5 хувь нь ажлын байраар хангагдсан байна.



2.10 Нийт төгсөгчдийг мэргэжлийн төрлөөр үзүүлбэл:

Д/Д	Мэргэжил	2014 он		2015 он		2016 он	
		Төгсөгч	Ажил эрхлэлт	Төгсөгч	Ажил эрхлэлт	Төгсөгч	Ажил эрхлэлт
1	Малын эмч	14	9	19	12	24	18
2	Агротехникч	6	4	7	5	0	0
3	Барилгын техникч	0	0	0	0	15	15
4	Барилгын сантехникч	42	36	33	23	30	20

5	Барилгын өрөг угсрагч	30	25	24	17	29	23
6	Барилгын засал чимэглэлч	68	49	47	32	42	31
7	Фермерийн аж ахуй эрхлэгч	10	7	23	20	0	0
8	Гагнуурчин	49	33	18	13	27	22
9	Тогооч	66	51	42	28	41	33
10	Үсчин	34	28	34	22	40	30
11	Гэр ахуйн цахилгаан тоног төхөөрөмжийн засварчин	7	4	16	12	12	9
12	Бетон арматурчин	31	28	27	23	20	12
13	Модон эдлэлийн мужаан	21	16	25	15	18	16
14	Талх нарийн боов үйлдвэрлэл технологийн ажилтан	0	0	14	9	28	20
15	Оёмол бүтээгдэхүүний оёдолчин	40	34	44	27	47	30
16	Гоо засал	7	5	13	10	28	16
17	Хүнд машин механизмын оператор	24	15	28	19	28	18
18	Эрчимжсэн мал аж ахуйн фермер	22	19	26	23	30	25
19	Санхүү бүртгэл тооцооны туслах ажилтан	29	23	16	9	16	9
20	Ойжуулагч	6	4	15	14	14	14
21	Жимс жимсгэнэ хүнсний ногоо самар боловсруулан даршлагч үйлдвэрлэл технологийн ажилтан	0	0	7	4	9	5
22	Барилгын цахилгаанчин	11	9	11	8	11	9
23	Барилгын мужаан	0	0	0	0	8	5
24	Нийт	517	399	489	345	517	380

Төгсөгчдийг чадваржуулах бизнес инкубатор төвийг модон эдлэлийн мужаан, оёдол эсгүүр, гэр ахуйн цахилгаан тоног төхөөрөмжийн засварчин, талх нарийн боов үйлдвэрлэлийн ажилтан зэрэг мэргэжлээр нээн ажиллуулах чиглэлээр ДЗОУБ-аас тоног төхөөрөмж нийлүүлэх сургууль байр барих нөхцөлтэйгээр төсөл хэрэгжиж үйл ажиллагаа явуулахад бэлэн болсон тул цаашид төгсөлтийн дараах суралцагчдыг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлагатай байна. Энэ хөтөлбөрийг хэрэгжүүлсэнээр төгсөгчдийг ажлын байраар хангах, өрхийн орлого нэмэгдэх боломж бүрдэх үр дүн харагдаж байна.

БҮЛЭГ 3: МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫГ ДЭМЖИХ САНГИЙН ХЭРЭГЖИЛТЭНД ТАВИХ ДОТООД ХЯНАЛТ:

Дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байгаа ч Шилэн дансны хуулийн хэрэгжилт сул байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэнд аймгийн мэргэжлийн хяналтын байгууллага хууль тогтоомжинд заасан эрх хэмжээний хүрээнд МСҮТ-ийн сургалтын дадлагын газар нь мэргэжилтэй ажилтан бэлтгэх шаардлага хангаж буй байдалд 17 асуулга боловсруулж судалгаа хийж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан ба мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 11.1, 11.2, 13.1, 13.3 дахь заалтууд 90% хэрэгжиж сургалтын орчин сайжирч 18% буюу бага эрсдэлтэй шалгагдсан байна.

Дотоод аудитын мэргэжилтэн болон сургуулийн сургалтын албанаас сар бүр Мэргэжлийн боловсрол, сургалтын чанарын хяналтын тогтолцоог нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж чадамжид суурилсан сургалтын явцын үнэлгээ, суралцагчдийн ирц, төсвийг зориулалтын дагуу зарцуулах, эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх чиглэлээр санхүүгийн дотоод аудит хийх, сургалтын чанарт хяналт тавин ажиллажээ.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянахад “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай” журамд заасны дагуу 2015 оны мэдээллийг бүрэн байршуулсан, 2016 оны эхний 8 сарын мэдээллийг бүрэн, 9 дүгээр сарын мэдээлэл, санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт, 2016 оны хагас жилийн санхүүгийн тайлантай холбоотой мэдээллийг байршуулаагүй тул аудитын явцад зөвлөмж өглөө.

Нийцлийн аудитаар төлбөр зөрчил илэрсэнгүй.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

1. Сангаас 255,3 сая төгрөгийн санхүүжилт олгож журамд заасны дагуу суралцагчдад олгосон байна.
2. Ерөнхий боловсролын бүрэн дунд боловсролын гэрчилгээ болон мэргэжлийн, техникийн боловсрол эзэмшиж нийт төгсөгчдийн 70,5% ажлын байраар бүрэн хангагдсан байна.

3. Дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байгаа ч Шилэн дансны хуулийн хэрэгжилт сул байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ :

Нийцлийн аудитын дүн дүгнэлтэнд үндэслэн Хөгжил Политехник коллежийн захирал Д.Баярмаа, ерөнхий нягтлан бодогч М.Өлзийхишиг нарт зөвлөх нь:

- Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, зарцуулах талаар аймгийн ИТХ-д уламжлан санхүүгийн дэмжлэг авах, орон нутгийн төсөвт тусгаж батлуулж үр өгөөжийг дээшлүүлэх
- Сургалтын материаллаг бааз, боловсон хүчний нөөц бололцоогоо ашиглан сургалтыг дэмжих сангийн үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор туслах аж ахуйгаас орох орлогын тодорхой хувийг сангийн үйл ажиллагаанд зарцуулах талаар анхааран ажиллах.

ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.ГАЛБАДРАХ

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР

Д.БАЛЖИННЯМ

Тэргүүлэх Аудиторын тушаал:



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬАА
ХОВД АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2016 оны 10 сарын 11 өдөр Дугаар 28 Ховд н

Аудитын тайлан, зөвлөмж, акт,
албан шаардлага батлах тухай

Төрийн Аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.7, 15 дугаар зүйлийн 15.1.12 дугаар заалт Монгол Улсын Ерөнхий аудиторов 2003 оны 53 тоот тушаалаар баталсан "гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4.2, 2016 оны А/95 тоот тушаалаар баталсан "акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1, 4.1 дэх заалт, аймгийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторов дэргэдэх зөвлөлийн 2016 оны 10 сарын 11-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ нь:

1. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилт, Засгийн газрын тусгай сангийн зарцуулалтанд хийсэн нийцлийн аудитын тайлан, зөвлөмж, акт, албан шаардлагыг хавсралтаар баталсугай.
2. Нийцлийн аудитын дүн дүгнэлтэнд үндэслэн аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга З.Лхамхүү-д ДААЛГАХ нь:
 - 2.1 Жаргалант сумын Модон овооны чиглэлд ойн зурвас байгуулах ажилд хийгдсэн гэрээний хэрэгжилтийг гүйцэтгэгч компаниудаар хангуулан хэрэгжүүлээгүй ажлыг дахин хийлгэж төсвийн хөрөнгийн үр өгөөжийг дээшлүүлэх
 - 2.2 Өмнөх жилүүдэд болон 2016 онд ойжуулалтын ажил гүйцэтгэсэн компаниудын ажлын гүйцэтгэл, модны амьдралтын хувьд үндэслэн гэрээний үүргийн биелэлтийг хангуулах талаар тодорхой ажлуудыг зохион байгуулах, улмаар өмнө онуудад ажлаа хангалтгүй хийсэн компаниудыг дараагийн ажлын гэрээ байгуулахгүй байх арга хэмжээг авч хэрэгжүүлэх
 - 2.3 Салбарын байгууллагуудыг бодлогоор ханган хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах
 - 2.4 Аймгийн хэмжээний байгаль орчныг чиглэлийн бодлого хэрэгжүүлэн ажиллаж байгаа мэргэжилтэнгүүдийн мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх
 - 2.5 Байгаль орчны мэдээллийн сангийн баяжуулалтыг үнэн бодиттой хийж хэвших

2.6 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос хуульд заасан хувь хэмжээгээр байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажилд зарцуулах талаар тодорхой ажлуудыг зохион байгуулах

2.7 Байгаль хамгаалах сангийн дансдыг сумдын төрийн санд нээж орлого зарлагын гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллах

3. Нийцлийн аудитын дүн дүгнэлтэнд үндэслэн Хөгжил Политехник коллежийн захирал Д.Баярмаа, Ерөнхий нягтлан бодогч М.Өлзийхишиг нарт ДААЛГАХ нь:

3.1 Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, зарцуулах талаар аймгийн ИТХ-д уламжлан санхүүгийн дэмжлэг авах, орон нутгийн төсөвт тусгаж батлуулж үр өгөөжийг дээшлүүлэх

3.2 Сургалтын материаллаг бааз, боловсон хүчний нөөц бололцоогоо ашиглан сургалтыг дэмжих сангийн үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор туслах аж ахуйгаас орох орлогын тодорхой хувийг сангийн үйл ажиллагаанд зарцуулах талаар анхааран ажиллах.

4. Нийцлийн аудитын зөвлөмж тавьсан акт, албан шаардлагыг барагдуулж дүнг 11 сарын 10-ны дотор танилцуулахыг аудит хийсэн аудитор, шинжээч нарт хариуцуулсугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.ГАЛБАДРАХ



Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал:



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ХӨГЖИЛ ПОЛИТЕХНИК
КОЛЛЕЖ**

84140 Ховд, Ховд аймаг, Утас/Факс: (976) 7043-3092

E-mail: Khovd_college@yahoo.com

2016.10.17 № 212
танай _____-ны № _____-т

**ХОВД АЙМГИЙН АУДИТЫН
ГАЗАРТ**

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн зарцуулалтад хийсэн нийцлийн аудитын тайлантай танилцлаа.

Нийцлийн аудитын тайланг хүлээн зөвшөөрч байна.

ЗАХИРАЛ

Д.БАЯРМАА

